



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠒ оны 11 сарын ᠐1 өдөр

Дугаар А/87Н

Ховд

Барилгын захиалагчийн хяналтын  
зардал шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх гэрээний дагуу “Шинэ Ховд” үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын захиалагчийн хяналтын зардлыг “Шинэ Ховд” баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-т шилжүүлсүгэй.

2. Хяналтын зардал болох 118,622,000 (нэг зуун арван найман сая зургаан зуун хорин хоёр мянга) төгрөгийг “Шинэ Ховд” баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ-т шилжүүлж, гүйлгээ хийхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Төгөлдөр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГ



Х.БАТБОЛД

8400001 2107

Zah A/874 Ba